

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
 “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан үйл ажиллагаа	Зорилт, үйл ажиллагаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Хийгдсэн ажлууд	Өмнөх долоо хоногийн хэрэгжилтийн хувь	Энэ долоо хоногийн хэрэгжилтийн хувь	Хүлээгдэж буй ажлууд	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал	Хариуцах байгууллага
0		1	2	3	4	5	6	7	8	9
4.2.2.	Шинэ суурьшлын бүс, эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	Налайх барилгын материалын үйлдвэр технологийн парк байгуулна.	2022	2024	<ul style="list-style-type: none"> Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дууссан, дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын БУА график, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгдэж байгаа бөгөөд одоогийн дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дуусаж техникийн комисс ажиллаж байна. Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж агаарын шугамын хүчдэлээ өгч туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Цэвэрлэх байгууламж, Дулаан хангамж, Гадна цахилгаан хангамжийн зураг төсөв, бөөний болон жижиглэн худалдааны төвийн /ХЕТ/ боловсруулах ажлыг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 229-233 дахь заалтад тусгуулсан. Нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлээд байна. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газар дээр нийт 65 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа болон үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд зарим үйлдвэрийн бүтээн байгуулалт ажил дуусаж тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад ороход 325 хүнийг байнгын ажлын байраар хангах ба одоогоор 3 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхэлж 162 хүнийг ажлын байраар хангаад байна. 	0%	30%	Паркийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн зураг төслүүдийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна.	Паркийн дэд бүтцийн санхүүжилт шаардлагатай байна. Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах.	НЗДТГ

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ